



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 507

Улаанбаатар хот

“Корэкс” ХХК-ийг виртуал хөрөнгийн
үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 174 дүгээр тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-ын 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Корэкс” ХХК-ийг виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэсүгэй.

2. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Корэкс” ХХК (М.Золжаргал)-д үүрэг болгосугай:

1/Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллах;

2/Бүртгэлтэй үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН